



“ХҮННҮ МЕНЕЖМЕНТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 3 сарын 13-ны өдөр
Улаанбаатар хот

№: 03/01

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам” болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2026 оны 4 сарын 24-ний өдрийн 15:00** цагаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /1420/, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 17 дугаартай Блю Скай барилгын 9 давхарт хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2026 оны 4 дугаар сарын 2-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, холбоотой бусад баримт бичгийг бэлэн болгож 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 18:00 цагаар тасалбар болгосугай.

8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

- ТУЗ-ийн Дарга М.Гантөгс

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

- Гүйцэтгэх захирал Ц.Билэгсайхан

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

- Ө.Бямбагэрэл “Ард Секюритиз ҮЦК” ХХК

Тооллогын комиссын гишүүн:

- Ч.Даваацэрэн “Ард Секюритиз ҮЦК” ХХК
- Б.Эрдэнэбилэг “Ард Секюритиз ҮЦК” ХХК

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ДАРГА



М.ГАНТӨГС